



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А/03

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Цагдаагийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”-ын 1.2 дахь хэсгийн “Төрийн нууцийн тухай хууль” гэснийг “Төрийн болон албаны нууцын тухай хууль” гэж, 3.2 дахь хэсгийн “Цагдаагийн ерөнхий газрын дарга, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга нарын” гэснийг “Хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэж тус тус өөрчилсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”-ын зургаадугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/Зургаадугаар зүйл:

“6.1.Албан болон хувийн хэргээр гадаад улсад зорчих, оршин суух хүсэлт гаргасан хүн өмнө нь эрэн сурвалжлагдаж байсан, эсхүл эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх талаар төрийн эрх бүхий байгууллага, гадаад улсын болон олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, Консулын болон дипломат төлөөлөгчийн газар лавлагаа хүсвэл цагдаагийн төв байгууллагын мэдээлэл нэгтгэн боловсруулах нэгж хариуцан өгнө.

3.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/195 дугаар тушаалаар баталсан “Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам”-ын 6.3 дахь хэсгийг хассугай.

4.Тушаалыг хэрэгжүүлж, ажиллуулах Цагдаагийн ерөнхий газрын дарга /цагдаагийн хурандаа Ц.Баатаржав/ хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Баясгалан/ нар тус тус даалгасугай.



Ц.НЯМДОРЖ

08 0009